



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 8/ЧӨ

Улаанбаатар хот

Дүүргийн хариуцлагатай эргүүл,
жижүүр томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сар шинийн баярын өдрүүдэд сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлж, албан байгууллага бүр хариуцлагатай эргүүл жижүүр томилсугай.

2. Байгууллага бүрт хариуцлагатай эргүүл жижүүр томилон ажиллуулахыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт, цахилгаан шугам сүлжээнд үүсч болзошгүй саатал, гэмтлээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг зохион байгуулан, томилгоот бүрэлдэхүүнээ тодотгон бэлэн байдлаа хангаж ажиллахыг Эрчим хүчний салбар (С.Алтанхүү)-т, Улаанбаатар Төмөр замын Эрчим хүч, ус хангамжийн 1 дүгээр ангийн хэсгийн мастер (Б.Ганзориг)-т, хэрэглээний халуун усны уурын зуухны хэвийн үйл ажиллагаа, багаж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг "Илч-Орд" ОНӨААТҮГ (Д.Гантулга)-т, Улаанбаатар Төмөр замын Барилга засвар ашиглалт үйлчилгээний ангийн Багахангайн зуухны механик (Б.Дуламсүрэн)-т, цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах хэвийн найдвартай ажиллагааг хангахыг Ус суваг ашиглалтын товчоо (Н.Батсайхан)-д, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг цагдаагийн хэлтэс (цагдаагийн хурандаа Т.Лхагвасүрэн)-т, гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т тус тус үүрэг болгосугай.

3.Дүүргийн хариуцлагатай эргүүлээр ажиллах онцгой комиссын гишүүдийн нэрсийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4.Эргүүл жижүүрээр ажиллахад шаардагдах 166,600 (нэг зуун жаран зургаан мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д, онцгой комиссын гишүүд, аж ахуйн нэгж байгууллагуудын хариуцлагатай эргүүл жижүүрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан тухай дүн мэдээг илтгэх хуудсаар 2023 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 10.00 цагт танилцуулж, санхүүгийн тайланг 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны *02* сарын *16* ны өдрийн *1140* дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт




ХАРИЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮРЭЭР АЖИЛЛАХ
АЛБАН ТУШААЛТНЫ НЭРС

Д/д	Овог, нэр	Албан тушаал	Утасны дугаар	Эргүүлээр ажиллах хуваарь	
				Эхлэх	Дуусах
1.	Г.Дагвадорж	Засаг даргын зөвлөх	99831606	2023.02.20	2023.02.21
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга	88769800		
2.	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга	88009107	2023.02.21	2023.02.22
	Ч.Магадсайхан	Газрын харилцааны албаны дарга	99510215		
3.	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга	99819181	2023.02.22	2023.02.23
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга	99105204		
4.	Н.Батсайхан	Ус суваг ашиглалтын товчооны дарга	89993819	2023.02.23	2023.02.24
	Н.Галбаатар	ОБХ-ийн ГЭУУДАХ мэргэжилтэн	95771674		
5.	Х.Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга	88892022	2023.02.24	2023.02.25
	Г.Ганзориг	Онцгой байдлын хэлтсийн орлогч, дэд хурандаа	91109184		
6.	Д.Гантулга	"Илч-Орд" ОНӨААТҮГ-ын захирал	99144813	2023.02.25	2023.02.26
	Б.Гэрэлмаа	"Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын захирал	99008292		
7.	С.Алтанхүү	Налайх эрчим хүчний салбар "Өндөр толгой" хэсгийн мастер	88091223	2023.02.26	2023.02.27
	М.Мөнхболд	ОБХ-ийн ГТУХ-ын байцаагч	86800276		

Хяналт шалгалтаар ажиллах хариуцлагатай эргүүл жижүүр нь дүүргийн онцгой комиссын даргад нөхцөл байдлыг утсаар илтгэж ажиллах.

Онцгой байдлын хэлтсийн шуурхай албаны 62-60 УБЧ автомашинтайгаар эргүүл хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх ба Засаг даргын тамгын газрын жижүүр дээр өглөө 09 цагт рапортын дэвтэрт тэмдэглэл хөтлөн дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 16 ны өдрийн 1740 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЭРГҮҮЛ ЖИЖҮҮРЭЭР АЖИЛЛАХАД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Нэг бүрийн үнэ	Бүгд
			өдөрт	нийт		
1	Шатахууны зардал (А-92)	литр	10	70	2380	166,600
2	Бүгд					166,600